



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/67


Улаанбаатар хот

Авто замын тэмдэг, хайс тоноглолын
ажлын задаргааг баталж, гүйцэтгэгчийг
сонгон шалгаруулах тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалт, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Нийслэлийн 2016 оны төсөв батлах тухай” 2015 оны 32/33 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2016 оны А/07, А/322 дугаар захирамжууд, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 1 дүгээр хэсгийн 1.3, 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Засаг даргын 2016 оны “Эрх шилжүүлэх тухай” А/07 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын дагуу Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2016 онд санхүүжих Авто замын тэмдэг, хайс тоноглолын ажлын задаргааг хавсралтаар баталсугай.

2. Дээрх хавсралтаар батлагдсан ажил болон Нийслэлийн Засаг даргын 2016 оны “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/322 дугаар захирамжийн дагуу Сүхбаатар дүүргийн орон сууцны хороолол доторх авто замын засвар, шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчийг шалгаруулж, зөвлөмж хүргүүлэн ажиллахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2016 оны А/15 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар байгуулагдсан Үнэлгээний хороо /Б.Энхбаяр/-нд үүрэг болгосугай.



ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Б.БАДРАЛ

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2016 оны *долоодугаар* сарын *06* -ны өдрийн
Н.А.Г.Гунд тушаалын хавсралт



АВТО ЗАМЫН ТЭМДЭГ, ХАЙС ТОНОГЛОЛЫН АЖЛЫН ЗАДАРГАА

№	Ажил	Тоо хэмжээ	Нэгж өртөг /төг/	Өртөг /сая төг/
1	Шинээр хийгдэх замын тэмдэг /гүйцэтгэлээр/	1100	110 000	121.0
2	Бөмбөгөр худалдааны төвийн баруун урд уулзвараас MN-25 суваг телевизийн хойд уулзвар хүртэл хайс суурьлуулах	160	95 000	15.2
3	Энхтайвны өргөн чөлөөнд Зүүн 4 замын уулзвараас Арслантай гүүр хүртэл замын хойд хэсэгт хайс суурьлуулах	400	95 000	38.0
4	Энхтайвны өргөн чөлөөнд 32-р байрнаас Цамбагарав хүртэл замын урд хэсэгт хайс суурьлуулах	600	95 000	57.0
5	Сөүлийн гудамжинд хайс суурьлуулах	315	68 000	21.42
6	Барсын зүүн уулзвараас Нарны гүүр хайс суурьлуулах	120	68 000	8.16
7	Мэдээллийн тэмдэг суурьлуулах	10	12 000 000	120.0
8	Тэмдэг, тоноглолын арчлалтын ажил /гүйцэтгэлээр/			38.72
9	Хайс нөхөн суурьлуулалт, арчлалтын ажил /гүйцэтгэлээр/			47.5
10	Хурд сааруулагч			20.0
11	Замын дохионы шон /тумбэ/			13.0
	Дүн			500.0